

УДК 930.85+94(5)(=512.3)

“ХӨХ СУДАР”-ЫН ӨНГӨ ГЭРЭЛ, ЗҮҮДНИЙ БЭЛГЭДЭЛ

В. Янжиндулам

Ph.D

Ховд их сургуулийн багш, Монгол улс

E-mail: yanjinvictor@gmail.com

Товч хураангуй

В. Инжаннашийн дүр бүтээх онцлог нь түүний ертөнцийг үзэх үзэл, гүн ухааны баримтлал тухайн нийгэм цаг үедээ хандаж байсан хандлагатай нь салшгүй холбоотой болно. Их зохиолч Инжаннаши зүйрлэл адилтгал, ихэсгэл багасгал, чимэг үгээс гадна тойруулал, ёгтлол, бэлгэдэл зэрэг уран дүрслэлийн аргыг өргөн хэрэглэсэн нь дорно дахины уран сайхны сэтгэлгээний уламжлалт ойлголттой холбоотой юм. В. Инжаннаш «Хөх судар» зохиолдоо гармоник дүрүүдийг илэрхийлэхийн тулд өнгө, гэрэл, мөрөөдлийг тэмдэг болгон ашигласан. Ялж, мандах үйл явдал, баатрын хүчийг цагаан гэрлээр, муу үйл, ялагдах үйл явдлыг хар уур, манантай харанхуйгаар дүрсэлбэл улаан гэрлээр илэрхийлжээ. Мөрөөдлөө зохиолд 22 удаа тайлбарласан байдаг. Мөрөөдлийн ихэнх нь ирээдүйд тохиолдож болох зовлон бэрхшээлийн бэлгэдэл юм. Зүүднээс хамааралтай үйл явдал олон бий.

Түлхүүр үг

В. Инжаннаши, бэлгэдэл, нэрийн бэлгэдэл, өнгө гэрлийн бэлгэдэл, зүүдний бэлгэдэл.

UDK 930.85+94(5)(=512.3)

THE SYMBOLISM OF COLOR AND DREAMS IN THE INJINASH'S "BLUE SUTRA" (KOKE SUDUR)

Yangindulam V.

Ph.D

Hovd University. Khovd, Mongolia

E-mail: yanjinvictor@gmail.com

Annotation

The great writer V. Injannashi used the colour, light, and dream as symbols to express the harmonic roles in his novel «Khukh sudar». Its worldview and philosophy are inextricably linked to the attitude of the society at the time. Injannashi used a wide range of figurative techniques, including metaphors, diminutives, vintage words, carousels, allegories, and symbols, which are related to traditional concepts of eastern artistic thought. The winning and the rising events, the power of the hero were expressed through white light, red light when the bad events and the losing events were described by black anger, foggy darkness. The dream is described 22 times in the novel. Most of the dreams are the symbol of troubles that may happen in the future. There are lots of events that are dependent on dreams.

Keywords

Injannashi, symbols, name symbols, color light symbols, dream symbols.

УДИРТГАЛ

В. Инжаннашийн «Хөх судар» роман нь уран дүрийн боловсруулалт, дүрслэхүйн ур ухаан, утга төгөлдөр яруу тансаг хэл найруулгаараа түүхэн сурвалжаас илт ялгардгийн учир нь аман зохиолын шавхагдашгүй баян сан, түүхэн сурвалжийн сонгодог бичгийн хэлэнд нь бий. Иймээс ч эрдэмтэн монгол судлаач Г. И. Михайлов «анхны монгол роман» (1969), эрдэмтэн Х. Буянбат «түүхэн үлгэр», эрдэмтэн Ч. Билигсайхан «ууган түүхэн роман» эрдэмтэн Дэлгэр «түүх биш уран зохиол» (1988) зэргээр үнэлж дүгнэсэн нь бий. Эрдэмтэн Т. Дэсрэйжав «Их зохиолч Инжаннашийн урнаар өгүүлэх аргын тухай» (1983), «Хөх судрын хэллэгийн онцлогийг туршин өгүүлэх нь», «Инжаннашийн үг хэрэглэх уран мэргэжлийн тухай», Сүеэ «Алдарт зохиолч Инжаннаши хийгээд ардын аман зохиол» зэрэг өгүүллүүд болон эрдэмтэн Б. Гэрэлтү «Монгол зохиолын онолын чимэг»(1998), «Монгол зохиолын онол өгүүлэхийн түүхэн шинжилгээ»(1998), Б. Содбилэг «Содбилэгийн зохиолын түүвэр» (1985), Т. Дэсрэйжав «Их зохиолч Инжаннаши»(1993), «Хөх судар хийгээд 10 анги судрын харьцаа»(1990), Үеэ «Инжаннаши ба түүний зохиол бүтээлийн тухай судлал» (2002), Г. Эрдэнэтогтох «Инжаннашийн тухай судлал» (1988) зэрэг бие даасан бүтээлүүдээ «Хөх судар» романы хэл уран сайхан, дүр, түүхэн судруудтай харьцах харьцааны асуудлыг хөндөн тавьжээ.

В. Инжаннашийн «Хөх судар» романы уран дүр, дүрслэл, хэл найруулгын асуудлыг Өвөр монголын судлаач Х. Буянбат «Хөх судрын урлагийн амжилт», «Хөх судрын илтгэх арга» гэдэг өгүүлэлдээ «Шууд илтгэх, тольтгол, адилтгал, зүйрлэл, харьцуулал, харилцан яриа, уянгалал, хүүрнэл, шүүмжлэн өгүүлэхүйн аргуудаар уран дүрийг бүтээсэн байна» (1988). Эрдэмтэн Эрдэнэхад «Төгс зохицонгуй туурвих ухаан» бүтээлдээ дүр дүрслэл бүтээх олон арга барилыг тодорхойлон үзжээ.

В.Инжаннаши нь түүхэн үйл явдлыг урнаар сэтгэмжилж, туурвин бичихдээ баян тансаг хэлнийхээ яруу сайхныг шилж сонгон утга уянга хослуулан чихнээ сонсголонтой байх зарчмыг барин, хэм тэгшлэн эс сондгойруулж, 7000 гаруй хоршоо үгийг хэрэглэснийг эрдэмтэн Д. Баасанбат судлан гаргаж, «Хөх судар»-ын хэвшмэл хэлц хэллэгийг нь түүн ангилан ялгасан нь их зохиолчийн хэл найруулгаас суралцагч эх хэл, үндэсний соёлоо өвлөн тээгч хэн бүхнээ чухал судалгаа шинжилгээ болсон юм. «Хөх судрын хэл найруулга маш яруу, сайхан зүйрлэл, цэцэн үг, яруу тодотгол, харилцан яриагаар элбэг баян. Энэ нь Хөх судрын туульсын яруу найргийн нөлөөгөөр бичигдсэний гэрч юм (1989) хэмээн монгол романы хөгжлийг судалсан эрдэмтэн Ц. Хасбаатар дүгнэжээ.

В. Инжаннашийн бүтээсэн дүрүүд нь зохиол бүтээгдэж байсан цаг үеийнхээ монгол тоотны амьдрал ахуйн нүднээ харагдахуйц яруу тодорхой тусгал болсон байдаг билээ. «Хөх судар»-ын дүр бүтээх урлагийн талаар эрдэмтэн Х. Буянбат «Хөх судар доторх хүмүүсийн дүр бол үнэн амьдралын өн шимлэг хөрс сууриас үндэс сурвалжтай мөртөө түүнээс нэн өндөр, нэн хурц төвлөрүүн болсон хэв шинжит уран дүр болно» (1982) хэмээн дүгнэсэн байдаг.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Цахар гэвш Лувсанцүлтэм, ханчин ханбо С.Жамьяангарав нар чимгийн мөн чанарыг тайлбарлахдаа «Дандин Анандавархан зэрэг их найрагч онолчдоос яруу найргийн дохиог өгч, ёгтоор өгүүлэх дхаванийн жам ёс баримтлан бичих»- ийг сургасныг дагалдаж байв. Дхаванийн жам ёсны яруу найраг нь үгийг шууд, шилжүүлсэн, далдалсан гурван утгатай байдаг» гэсэн ойлголт баримталж байсан нь өрнө дахины онолоор уран дүрийг бүтээх үндсэн гурван арга байна гэсэнтэй үндсэндээ дүйж байгаа юм. Үүнд,

1. Тодорхойлолзүйн арга
2. Харьцуулалзүйн арга
3. Бэлгэдэл зүйн арга болно

Бэлгэдэх сэтгэлгээ гэдэг бол угаас монголчуудын язгуур сэтгэлгээний нэг юм. Энэ нь байгаль дэлхийтэйгээ ойр байж, уул усаа эрхшээсэн эзэн савдагтай гэж үзэж, үгийн эрчим хүчийг мэдэрч, түүнийг олонтоо давтаас биежин бодитой болдог далд таталцлын хууль буй гэж үздэгээс үүдсэн цээрлэн эерүүлэх, нүүдлийн ахуй амьдралын хорио цээр, аман хууль, ёр бэлгэтэй ч холбогдох өвөрмөц сэтгэлгээ юм. Уран зохиолын онолд бэлгэдэл гэдэг нь эртний Грекийн «онцгойлон таних тэмдэг» гэдэг үгнээс гаралтай нэг талаас «уран дүрийг нөгөө талаас тэмдэг төлөөллийн шинж чанарыг хадгалдаг» (Байгалсайхан, 1998) «Хийсвэр санаа ойлголт зэргийг бодит байдлын ямар нэг уламжлан тогтоосон тодорхой юм үзэгдэлд шингээх эсвэл соёлын уламжлалын эсрэг зориуд бий болгосон өөр юмс үзэгдэлд дүрслэгдэхүүнээ шилжүүлж илэрхийлэхийг бэлгэдэл гэнэ» (Галбаатар, 2012).

Энэ нь нэгэн бодит юм үзэгдлийг нөгөө нэг зүйлээр бэлгэдэн шүтэж байсан ард түмний соёл сэтгэлгээтэй холбоотой юм. Бэлгэдлийг бүтээж байгаа хос элементийн нэг нь бэлгэдлийг бүтээж байгаа бодит юмсын дүр байдал, нөгөө талаас энэхүү дүр байдлын илэрхийлж байгаа гүн далд санаа гэсэн хоёр зүйлээс тогтоно. Сонгодог уран зохиолд бэлгэдлийн энэ чанар нь аажмаар гүнзгийрэн утга санаа, дүрийн зан төрхийг бэлгэдэн үзүүлэх болжээ. Бэлгэдлийн дүр үүсэхэд цаад жинхэнэ юмсын дүр утга агуулга нь цөм «тунгалаг сайхан» болж, бэлгэдлийн илэрхийлэх гэж буй утга нь тэрхүү дүрийн дундуур нэвт гэрэлтэн гарч ирнэ.

Тухайн ямар нэг юм буюу бэлгэдлийн тэмдгийн шинж нь юмс үзэгдэлд олон дахин давтагддаг түгээмэл эсвэл тухайн үндэстний хайрлан хүндэтгэдэг жигшин цээрлэдэг зан заншил, ахуйн сэтгэлгээний тогтсон ойлголттой нь холбоотой юм. Эрдэмтэн С. Дулам «Бэлгэдэл нь хөдөлгөөнгүй атлаа агшин зуурын, мэдээжийн атлаа үл танигдах тийм зүйл мөн. Бэлгэдэл бол мөн чанараараа сая сая хүний амин-бие-сэтгэл судлалын (Био-физио-психология) өв хөрөнгө, цуваа цагийн хувьд соёл иргэншлийн үүсэл хөгжил, дэвшлийн үр шим, хам цагийн үүднээс хүн бүрийн дотоод ертөнцийг зохируулж байдаг зөн совингийн болон оюун санааны хүч, ухамсар ба ухамсар бусын давхар илэрхийлэл» (1999) хэмээн үзсэн байна. Тодорхойлол болон харьцууллаар дүр бүтээх шиг илэрхий хялбархан ойлгогдож энгийн тоочин үзүүлдэггүй. Харин тодорхойлол харьцууллын олон хэлбэрээр бэлгэдэл илэрч болно. Уран сайхнаар нэгтгэн үзүүлж байгаа тэмдэгт чанар нь уран сайхныхаа дүртэйгээ нягт нямбай холбогдож бэлгэдэн илэрхийлж буй дүр нь зохиолчийн илэрхийлэх эцсийн зорилгод нийцсэн үед бэлгэдлийн дүр үүсдэг байна.

Ийнхүү зүүд совин, зан заншил, уран сэтгэмж зэрэг сэтгэлгээний болон зан үйлийн элдэв зүйлийн бэлгэдлээр уран дүр бүтээсэн нь В. Инжаннашийн «Хөх судар» романд нэн түгээмэл байдаг юм. Зохиолд зүүд зөн совин, далны мэргэ, шагайн мэргэ, цагаан элээний төлөг, нумын хөвчийн дуугаар ёр бэлгийг шинжих хийгээд шаазгай шувууг сайн муу хэл залгаж буй, ууль шувууг ирэх муу үйлийг ёрлон бэлгэдэж байгаагаар дүрсэлсэн байна. Оршуулах зан үйл, өргөл тахил, тангараг, хараал зүхэл зэрэг үндэсний онцлогийг илтгэх өгүүлэмж нь бэлгэдэл зүйн зарчимд тулгуурлажээ. Үүнээс тодруулан өнгө гэрлийн хийгээд зүүдний бэлгэдлийн тухай авч үзье.

ӨНГӨ, ГЭРЛИЙН БЭЛГЭДЭЛ

Монголчуудын зан үйл, шүтлэг бишрэл, ертөнцийг үзэх үзэл нь аливаа нэгэн үйл хэрэг, юм үзэгдлийг өнгөөр бэлгэдэхэд илэрч байдаг. Өнгөний бэлгэдлийн талаар эрдэмтэн Н. Л. Жуковская судалж «цагаан өнгө нь аз жаргал, элбэг дэлбэг байдал, цэвэр ариун үнэнч сайхан сэтгэл, хүндэтгэлийг бэлгэддэг бол хар өнгө нь үүний эсрэг хорон санаа гэрэл гэгээгүй, харгис ширүүн аз жаргалгүй үйл явдлыг бэлгэднэ. Улаан өнгө нь аз жаргал, шар өнгө нь хайр дурлал, сайхан сэтгэл, хөх өнгө мөнх оршихыг бэлгэддэг (Н.Л.Жуковская, 2002) гэж үзжээ. «Хөх судар» романы өгүүлэмжид өнгөөр бэлгэдсэн нь нэн түгээмэл. Тухайлбал, Тэмүжиний царайг улаан нарантай зүйрлэхийн зэрэгцээ «цагаан гэрэл туяаран цацрах» эсвэл «улаан гэрэл цацран» гэж дүрсэлсэн нь цог заль гоо үзэмж төгс, ариун тэнгэрийн хүү болохыг нь батлан дүрийн гадаад шинжээр дотоод чанарыг илтгэн гаргасан байна. Монгол ардын аман зохиолд улаан өнгө нь үлгэр туульсын баатрын үзэх дүр, сүр сүлд, ид хүчний бэлгэдэл, эрүүл чийргийн илэрхийлэл болон дүрслэгддэг уламжлал арвин. «Түмэн хүний сүрийг дарах түүхий улаан царайтай, мянган хүний сүрийг дарах мяндас улаан царайтай», «Бум Эрдэнэ буман хүний сүрийг дардаг будмал улаан царайгаа гаргаад», «түмэн хүн айх түүхий улаан царайгаа гаргаад» гэх мэтээр баатрын байр байдлыг дүрсэлсэн нь гал залуу нас, эрүүл саруул бие махбод, сүр жавхлант шинж чанарыг гүйцэд илтгэсэн байна. Туулийн баатрууд дунд ч Гунан Улаан Баатар, Арслангийн Араг Улаан Хонгор зэрэг галтай цогтой улаан зүсээрээ нэрлэгдсэн баатрууд олон. Энэ нь монголчууд эртнээс галыг шүтэн, гал голомтыг ариун байлгахыг эрхэмлэн, алив зүйлийг шатааснаар ариусан цэвэршдэг гэж үздэг байснаас улаан өнгөөр галыг бэлгэдэн «ариун дээд» гэсэн шинжийг илэрхийлнэ. Эрдэмтэн Д. Цэвээндорж баатарлаг туулийн баатрын өнгө зүсний дүрслэлийн тухайд «баатарлаг дүрийн эрдэм чадал, эрч хүчийг буюу гол дүрийн нүүр царайг улаан өнгөөр дүрслэн урлах хэв шинж нэгэнт бүрэлдэн тогтсон болно (2008) гэж үзээд, эмэгтэйн хувьд улаан өнгөний дүрслэл нь гоо үзэмж, сэтгэл хангалуун жаргалтай байдлыг илтгэдэг гэжээ. Нөгөө талаар, зохиолд улааныг шүтэх нь хятадын соёлтой ч холбоотой байж болно. Ертөнцийн үүслийн тухай домогт домгийн туурвигч баатар Матар Мэлхийг харвахад, амнаас гал бадран, өмнө зүг харж, унасан дээрээс улаан, гал зүг гэж нэрлэсэн учиртай, үүнээс улбаалан «Улаан хятад» гэдэг билээ.

«Хөх судар»-т өгүүлэхдээ, «Есүхэй баатрын хатан Өгэлүн үжин Чингис богдыг жирэмсэн ахуйд ...гэр дүүрэн **цагаан гэрэл** цацран туяарч» гэх буюу «Бөртэгэлжин хатныг төрөхүй хэдий чинээ давхар эсгийгээр бүрхсэн өргөө гэр бүрхүүлт зулын цаас мэт **улаан гэрэл** туяалсныг бүгдээр үзсэнээр» буюу эсвэл «Торгон шар хурим

тархаж гэртээ ирэхэд өвст нуурын дотор **улаан гэрэл** цацран гарахад» (Инжаннаши, 1957) хэмээх эдгээр дүрслэлд Тэмүжин хийгээд Бөртэгэлжин үжинээс ер бусын их гэрэл гэгээ, түүний дотроос улаан гэрэл цацран ойж буйгаар зурагласан нь монгол туулийн баатрын дүрслэлээс эхтэй бөгөөд зохиолч Тайцзугийн дүрийг ихэвчлэн «сүр гэрэл нь бадраад» хэмээн ерийн хүн харж чадахгүй сүрд нь дарагдаж байгаагаар дүрсэлсэн нь олонтоо байна.

Цахар гэвш Лувсанцүлтэм «Богд Ажаа Эрдэнийн магтаал»-ын шүлэгтээ

Бие нь бэлэг лагшны хот мандал дэлгэрсэн

Бэлэг билгийн зуун гэрлийн тороор хүрээлсэн

Балар харанхуй мунхаг бүхнийг арилган чадагч

Бадрагч наран мэт залуу Манзширийн ялгуугч

гэж шүлэглэсний дотор ариун бурхдын биеэс ялангуяа тэргүүнээс онцгой гэрэл цацран байдаг тул ийн дүрсэлжээ. Үүнчлэн В. Инжаннаши «Хөх судар» романд Тайцзугийн дүрийг улаан цагаан гэрлийн сүлжээнд зурагласан байх юм.

Ер нь зохиолд тэнгэрээс хамаатай «тэнгэрлэг дээд» чухам эрхэм зүйлийг улаан өнгөөр бэлгэдэн үзүүлсэн нь түгээмэл тохиолдож байгаа нь Монголчуудын галыг шүтэх нанхиадын улаанаар ялан мандахыг бэлгэдэх сэтгэлгээ нөлөөлсөн байх талтай. Үүнд:

«Энэ эх хүү хоёр хүмүүний чин үнэн сэтгэлээс нулимс унагаснаар хоосон огторгуйд гэнэт аянгалж, гучин хоёр ханат ордон цагаан өргөө гэрийн дээд өрх нүхийн уруу нэгэн зурвас **улаавтар гэрэл** гэрэл нэгэн хасын аягыг бүрхсээр бууж ирэн Тайцзугийн баруун гарт тусав» (Инжаннаши, 1957).

«Жэу улсын Эү ван Шан улсыг дайлахаар цэргийн хүрээнд бүхий онгоцоор Мин-гийн олонд хүрснээ найман тохой урт мөнгөн загас онгоцонд гаргаж, шөнө бас монгол гэрийн өмнө огторгуйгаас нэгэн улаан гэрэл бууж ирээд, үүдний өмнө нэгэн шувуу хувилан гэрт нисэн орж, гэнэт бас нэгэн **улаан өнгөт** хаш болон хувилж унабай. Цохивоос хувын дуу гарбай» (Инжаннаши, 1957).

Энэхүү гэрлийн дүрслэл бүхий өгүүлэмжээр үйл явдлын болзол, нөхцөл шалтгаан, үйл явдал өрнөн, дүрийн зан төрх илрэх тохироог дүрслэн, гэрэл гэгээгээр тэнгэрлэг бадрангуйг үзүүлсэн бол үүний эсрэг аз хийморьгүй, тэнгэр үл таалсан хийгээд муу ёр, муугийн дохиог «харанхуй»-аар бэлгэдсэн байна. Тухайлбал:

«Алтан улсын Чэн Зэу хотын дээр нэгэн анги **хар уур** мандан бүрхэж, нарны гэрэл **бүрхэг харанхуй бурангуйд** хажуугаас үзэхүл хар үүлнийг хөндөлссөн мэт» (Инжаннаши, 1957) «тэр шөнө бас тэнгэр **харанхуй** болж үүлэрхсэнд Мухули тэнгэрийн зүг хандаж их дуугаар өгүүлрүүн: Тэнгэрийн муу ёр арилагтун хэмээв» (Инжаннаши, 1957) гэж дүрсэлсэн нь өгүүлэмжийг хурцатган, санааг лавшруулсан байна. Тэмүжинийг мандан гарч буй наран өөд асан бадрах галын улаан гэрлээр бэлгэдэж, тэнгэр заяатан хэмээн дүрслэхээс гадна тэнгэрийн цагаан өнгөтэй эсрэг-цүүлэн муу үйл хэрэг, сөрөг талын баатраас **муу уур** гарч, «**хар уур гарч**», «**хар уур бүрхэн**» байгаагаар дүрсэлсэн нь тэнгэрийн улирал муудсаны бэлгэ шинжийг илтгэнэ. Ер нь монгол соёл зан үйлийн сэтгэлгээнд сайн удирдагч гарч тэнгэрийн таалалд нийцсэнээр хур бороо цагтаа орж тааламжтай улирал ирж, тариа ногоо цагтаа ургаж, мал сүрэг нь тарга хүчээ авч өнөтэй тайван сайхан амьдрал бүрддэг. Харин ухаан муу охор бодолт таагүй удирдагч гарч ирснээр түмэн олны сэтгэлд нийцгүй бодлого явуулснаар сэтгэл нь хямарч, уур уцаар, зовлон гуниг ихэсч, үүнээс

муу уур дээш дэгдэн агаар тэнгэрт хүрч тэр нь нөлөөлөн их цас үер бууж, тэр нь ган зуд гамшиг зовлон нүүрлэн өвс ургамал гарахгүй мал амьтан өлбөрч, хүмүүс ядууран хоосроход хүрдэг хэмээн маш энгийн зүйлээс ургуулан сэтгэж тэнгэрийн ааш араншин буюу «их тэнгэрийн таалал»-ыг тайлбарласан байдаг.

«Хөх судар»-т өнгө гэрлээр тэмдэг болгон зохиолын явдлыг урьдаас бэлгэдэн үзүүлэхээс гадна өнгөний тухай зориуд дурдсан нь бий. Их зохиолч В. Инжаннаши монгол, нанхиадын ард түмний өнгөний бэлгэдлийн талаар Өгэлүн эхийн насан хутаг болохуйд гашуудан буй бэлэвсрэлийн ёсыг өгүүлэхдээ, «Монгол цөм хар өнгөөр бэлэвсрэн, Хятад цөм цагаан өнгөөр бэлэвсрэв. Учир юун хэмээвээс? Монголын уг нь Энэтхэгийн үндэс тул Энэтхэгийн ёсоор цагаан өнгийг охь өнгө, хар өнгийг адаг өнгө цагаан өнгө түмэн зүйлийн өнгөөр цөм хувилан чадах тул цагааныг түмэн зүйлийн эх өнгө болгожээ. Түмэн зүйлийн өнгө хар өнгөнд орвоос дахин бус өнгө хувилан чадахгүй тул, хар өнгийг түмэн өнгийн адаг муу өнгө болгожээ. Тийнхүү, эзэн хаан ба эцэг эх нь үхвээс бүгдээр цөм харанхуй шөнө мэт болов. Түүний бие эгнэгт харлав. Үхсэнгүй боловч, үхсэн лүгээ ялгалгүй болов хэмээн хар өнгөөр бэлэвсрэв» хэмээн соёлын онцлогийг дурджээ.

Энэхүү өнгө гэрлээр бэлгэдэн дүрсэлснийг дүгнэн үзвэл «улаан цагаан гэрэл» зөвхөн эерэг талын баатрын тэнгэрлэг эрхэм дээд болохыг бэлгэдэж байна.

Буддын шашны сургаал ёсоор умайгаас төрөх, өндөгнөөс төрөх, чийг дулаанаас төрөх, хувилж төрөх гэдэг дөрвөн янзын төрөлт байдгаас хувилж төрөх гэдэгт Тайцзугийн төрөлтийг холбож үзсэн ажээ. Эрдэмтэн С. Дулам «Бөө онгодоо дуудаж тамлах үес тэд тэнгэр асрын орноосоо гэрэл туяаны хувилал болон ялгарч гэрийн өрхөөр орж, хэнгэргийн задгай талаар тосон авангуут бөөгийн сугаар нэвтрэн зүрхэнд нь шунгадаг» гэснээс үзэхүл бидний өвөг дээдэс өнгө гэрлийн хувилгаан чанарыг билгийн нүдээр харах чадалтай, эрхт хөх тэнгэрээс гэрлээр дамжин эрч хүч, эрдэм чадлаа аван төрдөг гэж үздэгээс өнгө гэрлийг шүтэх үзэл санаа нь ийн үлгэр домгийн өгүүлэмж болон бидэнд иржээ.

ЗҮҮДЭЭР БЭЛГЭДЭХ

«Хөх судар» романд зүүдээр зохиомжлон ирэх цагийн гай барцад, муу ёр болон зол жаргал сайн үйлийг зөгнөн бэлгэдсэн байна. В. Инжаннаши «Хөх судар» романд нийт 22 удаа зүүдний бэлгэдлээр уран дүр, дүрслэл бүтээжээ. Зүүдийг барьж нэр өгөх, зүүдээр сэрэгдэж ёрыг урьдаар мэдэх аж. Тухайлбал, Зохиолын 17-р бүлэгт Өгэлүн эх «Өчигдөр шөнө бас нэгэн жигтэй зүүд зүүдлэв. Хөвгүүн чамайг нэгэн цусны худгаас татаж гаргав хэмээн зүүдэлсэн тул миний дотор нэн амаргүй болов» гэсэн зүүдэнд цусны худаг хэмээсэн нь нэн даруй Сарлагийн Зальт хаантай хуйвалдсан Тайчуудын Чилгэр бөх Тэмүжинг хэдэн тохой урт нүхэнд унагаж алах гэснийг ёрлон мэдсэн ажээ. Түүний бэлдсэн жадат нүхэнд унах аюулаас Оршигчийн бэлэглэн барьсан алтан өдөт начин шувуу тэргүүлэн Тайзуд бэлтгэсэн магнаг олбогноо суусанд, шувууг авахуйд хумс нь тэр олбогт шигдэн дээш хөөрөөд хар нүх харагдан, хамаг мэх нь задарч начин шувуу эзний амийг аварч буйгаар дүрсэлсэн байна. Энэ муу зүүдний учир Тайзуд элч илгээн сэрэмжлүүлж, үүнийг дуулсан Мухули шууд цэргээ аван их авын газар угтан очиж, хүч тэнцвэргүй тулаанд ялж байна.

Ер нь Монголчууд «цус» зүүдлэхийг алалдан байлдах, өвдөх үхэхийн шинж гэж үзэн ихэд цээрлэдэг билээ. Ингэж дүрийн логик хөгжилд юу тохихыг урьдаас зүүдээр дохиолон мэдэгдсэнээр түүнээс сэрэмжлэн чадаж байна.

Мөн «Өчигдөр шөнө миний зүүдэнд нэгэн их цагаан шонхор шувуу амандаа улаан нарныг зууж ирээд миний өргөө гэрийн тоонон дээр суув хэмээн зүүдэлсэн билээ» (Инжаннаши, 1957) гэсэн нь нэгэн сайныг зөгнөсөн зүүд бөгөөд «цагаан шонхор» хэмээгч нь хиад ястны шүтээн сахиус бөгөөд «улаан нар» хэмээн Тэмүжинийг наранд адилтган тойрууллын ур маяг ашиглан дүрсэлж, Дай Сэцэний өргөөний тоонон дээр суусан нь даруй охин Бөртэгэлжин лугаа ураг барилдахыг зөгнөсөн байна. Энэхүү зүүд нь монгол түүхэн сурвалжаас уламжлалтай юм.

Зохиолд Солонгуа «гурван шөнө дараалан түүний эцэг нь хагас толгой ба биеийг үхрийн шалз шиг шарж иднэ гэж зүүдлээд бөө онгод, цагаан элээний зүйлээр үзүүлэхэд цөм муу» (1957) гэснээр Полгудайг зарж явуулах бөгөөд Жамухын хорон санаа, арга мэхэнд эрсдэхийг урьдаас дохиолсон байна.

ҮР ДҮН

«Хөх судар»-т сонин содон зүүдний учир нэрийг оноон өгсөн тухай өгүүлэмж нэлээд бий. Зохиолч дүрд тохих элдэв учралыг бэлгэдлийн түмэн янзын хэлбэрээр илэрхийлэхийн зэрэгцээ тодорхойлох хийгээд харьцууллын аргаар уран дүрээ амилуулж чадсан юм. Ийм ч учраас эрдэмтэн Х. Буянбат «дүрслэл ба уянгалаг нь ямагт харилцан уусаж, хоорондоо идэшээд, шүлгийн сэтгэлгээ зургийн санаатай бүхэл бүтэн урлагийн цогцос болж байдаг» (1981) гэж үнэлсэн нь бий.

Энэ бүхнээс үзэхэд «Хөх судар» романд уран дүрийг бүтээхдээ В. Инжаннаши өнгө, гэрэл, зүүдээр дохио тэмдэг, ёр зөгнөл болгон бэлгэдэж, уран дүрийг бүтээжээ. Баатрын нэрийг ч ихэд бодолцон ёр бэлгэдлийн утгад шүтүүлэн оноосон байна. Ийнхүү тодорхойллын уран дүр бүтээх шууд арга, харьцууллын дам арга, бэлгэдлийн утгын аргаар «Хөх судар» романы уран сайхны дүр дүслэлийг нүднээ харагдам яруу сайхан бүтээжээ.

Ном зүй

- Байгалсайхан, С. (1998). *Уран дүрийн онолын лекцүүд*. Улаанбаатар.
- Буянбат, Х. (1981). *Инжаннаши ба түүний Хөх судрын тухай*. Хөх хот: ОМАХХ.
- Буянбат, Х. (1982). Хөх судрын хүмүүсийн тухай. *ӨМБДС-ийн эрдэм шинжилгээний сэтгүүл*, 3, 43.
- Буянбат, Х. (1988). *Инжаннаши ба түүний Хөх судрын тухай*. Хөх хот: ОМАХХ.
- Галбаатар, Д. (2012). *Уран зохиол, онол, түүх, шүүмжлэл, нэвтэрхий толь*. Улаанбаатар.
- Дулам, С. (1999). *Бэлгэдэл зүй-1*. Улаанбаатар: МУИС.
- Дэлгэр, (1988). Хөх судрын гол баатрын зан чанарын бүтэц ба систем. *ӨМИС-ийн эрдэм шинжилгээний сэтгүүл*, 3, 107.
- Дэсрэйжав, Т. (1983). Их зохиолч Инжаннашийн урнаар өгүүлэх аргын тухай. *ӨМИС-ийн эрдэм шинжилгээний сэтгүүл*, 2.
- Жуковская, Н.Л. (2002). *Кочевники Монголии. Культура. Традиции. Символика*. Москва: «Восточная литература».

- Инжаннаши, В. (1957). *Хөх судар*. Хөх хот.
- Михайлов, Г. И., Яцковская К. Н. (1969). *Монгольская литература: Краткий очерк*. Москва: Наука.
- Хасбаатар, Ц. (1989). *Уран зохиолын тэмдэглэл*. Улаанбаатар: Улсын Хэвлэлийн Газар.
- Цэвээндорж, Д. (2008). *Монголын утга зохиолын дүрийн онол*. Улаанбаатар: Балжу сан.

References

- Baigalsaikhan S. (1998). *Lectures on artistic theory*. Ulaanbaatar.
- Buyanbat H. (1981). *About Injannashi and his «Khukh sudar»*. Hohhot.
- Buyanbat H. (1982). About the people of the «Khukh sudar». *Academic journal*, 3, 43.
- Buyanbat H. (1988). *About Injannashi and his «Khukh sudar»*. Hohhot.
- Galbaatar D. (2012). *Literature, theory, history, criticism, encyclopedia*. Ulaanbaatar.
- Dulam S. (1999). *Symbolics-I*. Ulaanbaatar.
- Delger (1988). Structure and system of character of the main hero of the «Khukh sudar». *Scientific journal*, 3, 107.
- Desrejav T. (1983). About the method of articulation of the great writer Injannash. *Scientific journal*, 2.
- Zhukovskaya N.L. (2002). *Nomads of Mongolia. Culture. Traditions. Symbolics*. Moscow (in Russian).
- Ingannashi V. (1957). *Khukh sudar*. Hohhot.
- Mikhailov G. E., Yatskovskaya K. N. (1969). *Mongolian Literature: A Brief Essay*. Moscow: Nauka (in Russian).
- Khasbaatar T. (1989). *Literary notes*. Ulaanbaatar: State Publishing House.
- Tseveendorj D. (2008). *Character theory in Mongolian literature*. Ulaanbaatar: Balju Foundation.